

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес редакции: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес издателя: 191186,
Санкт-Петербург, д. 18.
Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведческих исследований

Том XXVI • 2023 • № 1

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Номер посвящается юбилею монголоведа
Нины Павловны Шастиной (1898–1980)

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор, доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук (Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поц, *доктор наук (Румыния)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 24.03.2023

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

e-mail: editor@isvov.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/kp5x-gtke-a669

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2023

© Коллектив авторов, 2023

В НОМЕРЕ:

С. С. Сабрукова. Обзор личного фонда Н. П. Шастиной (1898–1980) в Архиве востоковедов ИВР РАН	5
---	---

ИСТОРИОГРАФИЯ. ИСТОЧНИКОВЕДЕНИЕ. ИСТОРИЯ

Р. Ю. Почекаев. Процесс 1251 г. и Мункесар-нойон: к вопросу о статусе судьи-дзаргучи в Монгольской империи XIII в.	14
Ю. И. Елихина. Находки из Южного Хангая монголо-тибетской экспедиции П. К. Козлова в коллекции Государственного Эрмитажа	22
Т. Д. Скрынникова. «Плач» Толуя в «Тайной истории монголов»	29

ФИЛОЛОГИЯ

Ч. Заяасүрэн. Хүүхдийн оюун ухааны хөгжилд аман зохиолын бага төрөл нөлөөлөх нь (О влиянии малых жанров фольклора на интеллектуальное развитие детей)	35
Г.-О. Батзаяа. Монгол хэл, аялгуунуудыг ангилан хуваалаан түүх, өнөөгийн байдал (История и современное состояние классификации монгольских языков и их диалектов)	41
Ц. Б. Селеева. Поэтические особенности калмыцких народных загадок	61
Б.-Х. Б. Цыбикова. Традиционный фольклор в бурятских диаспорах Китая и Монголии	73
Д. В. Убушиева. Иван Иванович Попов и его коллекция калмыцкого фольклора	80

НАУЧНАЯ ЖИЗНЬ

Ю. В. Болтач. Одиннадцатые петербургские тибетологические чтения (28 ноября 2022 г., ИВР РАН)	93
Т. Г. Басангова. Труды фольклористов Калмыцкого государственного университета им. Б. Б. Городовикова за 2022 год	98
Н. В. Ямпольская. Рец. на: Чингис хааны нийслэл Хархорум хотын өв / Ред. А. Энхтөр, ерөнхий ред. Г. Эрэгзэн, С. Чулуун. 2021. – 244 х.	101

IN MEMORIAM

М. П. Петрова. Памяти Д. Цэдэва (1940–2023)	105
--	-----

Гэрэлт-Од БАТЗАЯА
Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

МОНГОЛ ХЭЛ, АЯЛГУУНУУДЫГ АНГИЛАН ХУВААЛААН ТҮҮХ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол хэлний нутгийн аялгуунуудын онцлогийг сурвалж бичгүүдэд эртнээс нааш тэмдэглэж ирсэн боловч XIX зуунд нутгийн аялгуу судлал бие даасан салбар ухаан болон хөгжиж, өнөөдрийг хүрчээ. Энэхүү хоёр зуугаад жилийн хугацаанд монгол хэлнүүд, нутгийн аялгуунуудыг ангилан хуваах талаар цөөнгүй санал дэвшигдэж иржээ. Тэдгээр эрдэмтэн, судлаачдын хуваарилсан байдлыг бид шүүрдэн авч үзээд, дараа нь чухам хэрхэн ангилан хуваах зарчмыг дурдаж, эцэст нь өнөөдөр монгол төрлийн хэчнээн хэл, тэдгээрийн дотор хэчнээн нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуу байгаа (халхажсан, буриададжсан, ойрадажсан байдлыг нарийвчлан авч үзсэний үндсэн дээр)-г нарийвчлан тоочин гаргаж, ярилцагч хүн амын тоог сүүлийн үеийн мэдээ баримтаар дурдав.

Түлхүүр үг: монгол хэлнүүд, аялгуунууд, ангилал, түүх, өнөөгийн байдал: хэл, аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуу, хүн амын тоо

Зохиогчийн тухай: Гэрэлт-Од БАТЗАЯА, D. Sci (Philology), дэд профессор, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн-гийн Хэл шинжлэлийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан (Улаанбаатар, Монгол Улс) (batzaya@mas.ac.mn).

© ИВР РАН 2023


© Г.-О. Батзаяа 2023

Нэг. Монгол хэл, аялгуунуудыг ангилан хувааж ирсэн түүх

Монгол хэлний нутгийн аялгуу судлалын эхэн үед А.Д. Руднев, Г.И. Рамстедт, Б.Я.Владимирцов нарын эрдэмтэд монгол хэлний дотор Монгол улс, Хятад улсад тархан суурьшсан монголчуудаас гадна Орос улсад суугаа халимаг, буриад, улмаар Афганистан дахь монгол, Хятадын зарим муж нутгаар суусан дагуур зэргийг оруулан, монгол хэлний нутгийн аялгуунуудын тоонд багтааж байжээ. Харин монгол хэл, аялгуунуудын судалгаа өргөжиж, илүү бүрэн гүйцэд бүртгэн хамруулахын

хэрээр монгол хэлний хөгжлийн янз бүрийн үе шатанд бие даан салж хөгжсөн хэлнүүдийг эрдэмтэд судалж, тэмдэглэж, ангилж ирсэн байна. Үүнд: Н. Н. Поппе, Г. Д. Санжеев, Чингэлтэй, Ш. Лувсанвандан, Г. Дөрфер, С. Мөөмөө, Ю. Мөнх-Амгалан, Ю. Янхунен, Д. Төмөртоогоо, Ж. Санжаа, Г. Батзаяа, Ж. Цолоо, Кан Шин, Д. Төмөртоогоо, Г. Гантогтох нарын олон эрдэмтэн хэрхэн ангилсныг, мөн “Дэлхийн хэлнүүдийн атлас” болон “Монгол судлалын нэвтэрхий толь (Үг хэл, үсэг бичиг)”-т хэрхэн ангилан хуваасныг шүүрдэж үзье.


Эрдэмтэн А. Д. Руднев “Опыт классификация монголов по наречиям” [Руднев, 1908] бүтээлдээ:



Бүдүүвч 1. Монгол хэлний аялгуунуудыг ангилсан эрдэмтэн А.Д.Рудневийн ангилал

хэмээн гурван бүлэг, арван нэгэн аялгуу болгон хуваажээ.


Эрдэмтэн Г. И. Рамстедт “Сравнительная грамматика фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора” [Рамстедт, 1908] бүтээлдээ:



Бүдүүвч 2. Монгол хэлний аялгуунуудыг ангилсан эрдэмтэн Г.И.Рамстедтийн ангилал

хэмээн гурван бүлэг, найман аялгуу болгон ангилжээ.

Эрдэмтэн Б. Я. Владимирцов “Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия” [Владимирцов, 1929] бүтээлдээ:



Бүдүүвч 3. Монгол хэлний аялгуунуудыг ангилсан эрдэмтэн Б.Я.Владимирцовын ангилал

хэмээн хоёр салаа, долоон аялгуу, мөн тэдгээрийн дотор арван нэгэн салбар болгон ангилсан байна.


Эрдэмтэн Н. Н. Поппе “Монгол хэлний харьцуулсан шинжлэлийн удиртгал” [Поппе, 1936] бүтээлдээ:



Бүдүүвч 4. Монгол хэлнүүдийг ангилсан эрдэмтэн Н.Н.Поппегийн ангилал

хэмээн хоёр салаа, долоон хэл гэж ангилаад, дорнод салаан дахь дагуур, монгол, зүүн монгол, буриад хэлнүүдийн доторх аялгуунуудыг бүртгэсэн байна.

Эрдэмтэн Г. Д. Санжеев “Монгол хэл аялгууны учир” [Санжеев, 1957] бүтээлдээ:



Бүдүүвч 5. Монгол хэлнүүдийг ангилсан эрдэмтэн Г.Д.Санжеевын ангилал

хэмээн зургаан монгол хэл байна гэж бүртгэжээ.

Эрдэмтэн Чингэлтэй “Дундад улс дахь монгол төрөл хэл ба нутгийн аялгууны ерөнхий байдал” [Čenggeltei, 1957] бүтээлдээ:




Бүдүүвч 6. Монгол хэлнүүдийг ангилсан эрдэмтэн Чингэлтэйгийн ангилал

хэмээх зургаан хэлийг бүртгэжээ.

Дээрх эрдэмтдийн, монгол хэлний аялгууг ангилсан туршлагыг академич Ш. Лувсанвандан “Монгол хэл аялгууны учир” өгүүлэлдээ -“Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудлууд”: “А.Д. Руднев, монгол хэл аялгууны тухай баримт мэдээ бүрэн бүтэн болоогүй байсан учир жинхэнэ хэлний нь шинж байдлыг харгалзалгүй, гол төлөв эртний овог аймаг, засаг захиргааны хуваарийг баримталсан шинжтэй болжээ. Г.И. Рамстедт энгийн бөгөөд товч ангилал хийсэн нь үндэслэл сайтай болж, дараагийн эрдэмтдийн судалгаанд зохих нөлөө үзүүлэхүйц болсон юм. Б.Я. Владимирцовын ангиллыг А.Д. Рудневийн ангилалтай зэрэгцүүлэн үзвэл, монгол хэл аялгууны тухай үлэмж нарийн хэрэглэгдэхүүнийг үндэслэн, бодот байдлыг нарийн ажиглажээ. Гэвч энэ үед Өвөрмонголын олон аялгууг сайн судлаагүй байсан учир Өвөрмонголын аялгууг мөн л засаг захиргааг баримтлан ангилжээ. Ялангуяа Шинжаан, Хөхнуур, Ганьсу мужийн монголчуудын хэл аялгууны тухай материал орсонгүй. Г.Д. Санжеев монгол угсаатны овог аймгийн тархай бутархай байдал, мөн түүнийг үндэслэн тогтоосон засаг захиргаа, улс төрийн хуваарийг ихээхэн анхаарсан байна. Ар, өвөр монголын

олон аялгууг нэгэн монгол хэлний нутгийн аялгуу гэж үзсэн нь үнэн байдалд нийлэвч, ойрад, буриад хоёрыг тус тусдаа биеэ даасан хэл гэж үзсэн нь эргэлзээтэй. Н.Н. Поппегийн ангилал нь Г.Д. Санжеевийн ангилалтай бараг адилхан боловч гагцхүү Халимагийг тусгайлан биеэ даасан хэл гэж үзсэн байна. Энэ ангилалд бие биесээ монгол гэж нэрлэдэг эсэхээр нь биеэ даасан хэл болох эсэхийг тогтоох зорилго тавьжээ. Гэвч энэ нь гол баримжаа болох аргагүй. Орчин цагийн монгол угсаатан олонх нь биесээ хуучныхаа овог, аймгийн нэрээр нэрлэхгүй болж, гол төлөв орон нутаг, засаг захиргааны нэрээр ялган цөм монгол гэж хэлэлцэх болж байна. Үүний урьд монгол хэл аялгууг туршин ангилсан хүмүүсийн гарт Дундад улсын доторх монгол угсаатны хэл аялгууны тухай ийм арвин их хэрэглэгдэхүүн байсангүй. Иймээс нөхөр Чингэлтэй монгол хэл аялгууг дан ганц овог аймаг буюу засаг захиргааг нь баримтлалгүй, юуны өмнө хэлний шинж буюу аль зэрэг харилцан нэвтрэлцэж чадах эсэхийг нь ихээхэн анхаарч ангилсан учир өнөөдрийн бодот байдлыг илүү нарийн тусгаж чадсан байна” [Лувсанвандан, 2002. Х. 38–43] гэх мэтээр үнэлж дүгнээд, өөрийн ангиллыг дэвшүүлсэн нь:




Бүдүүвч 7. Монгол хэлний аялгуунуудыг ангилсан академич Ш.Лувсанвандангийн ангилал

хэмээн, эдгээр аялгуутны өөр хоорондоо хэрхэн харилцан нэвтрэлцэж байгаагаар нь баримжаа болгож, монгол угсаатны түүх нийгмийн хөгжилтэй холбон тайлбарлаж, хилийн чанад орших ойрад, буриад, өвөр монголчуудын хэлэлцэх хэл аялгуут хамарч ангилсан байна. Ингэж ангилахдаа хилийн чанад дахь Халимаг, Буриад улсын монголчууд, түүнчлэн Өвөр Монголын хорчин, харчины хүн амын хэлэлцэх хэл яриаг монгол хэлний аялгуу гээд, Монгол улсад нутаглаж буй ойрад, мөн Хөхнуур, Алшаа эзнээгийн ойрадыг төв-өрнөдийн завсрын аман аялгуу, Монгол улсад нутаглаж буй буриад, Өвөр Монголын барга буриадыг төв-умардын завсрын аман аялгуу, баарин, ар хорчин, онниудыг төв-дорнодын завсрын аман

аялгуу хэмээн тус тус ангилжээ. Харин могол, монгор зэргийг төрөл хэл хэмээн үзээд, дээрх хүснэгтэд оруулсангүй. Мөн 1966 оны бас нэг бүтээлдээ дагуур, монгор, моголыг “тасархай аялгуунууд” хэмээн нэрийдсэн бөгөөд энэ мэтээр монгол хэлнээсээ ихээхэн тасран холдсоныг хүлээн зөвшөөрчээ.

Германы эрдэмтэн Г. Дөрфер “Classification und Verbreitung der mongolischen Sprachen” [Doerfer, 1964. P. 34–50] бүтээлдээ хэмээн монгол хэлийг гурван бүлэгт хуваагаад, найман хэлийг багтаажээ.

Эрдэмтэн С. Мөөмөө, Ю. Мөнх-Амгалан нар 1984 онд хэвлүүлсэн “Орчин үеийн монгол хэл аялгуу” [Мөөмөө, Мөнх-Амгалан, 1984] хэмээх бүтээлдээ:




Бүдүүвч 9. Монгол хэлнүүдийг ангилсан эрдэмтэн С.Мөөмөө, Ю.Мөнх-Амгалан нарын ангилал

хэмээн есөн хэл болгон ангилжээ.

Академич Д. Төмөртоого 1992 онд хэвлүүлсэн “Монгол хэлний түүхэн хэлзүй” [Төмөртоого, 1992], 2002 онд хэвлүүлсэн “Монгол хэл шинжлэлийн онол, түүхийн асуудлууд” [Төмөртоого, 2002] хэмээх бүтээлүүддээ:

хэмээн 11 хэл болгон авч үзсэн байдаг.


Финляндын эрдэмтэн Ю. Янхунен 2003 онд хэвлүүлсэн “Монгол хэлнүүд” [Janhunen, 2003] хэмээх бүтээлдээ:



Бүдүүвч 11. Төв монгол хэлний аялгуунуудыг ангилсан эрдэмтэн Ю.Янхунений ангилал

Эрдэмтэн Г. Батзаяа 2008 оны бүтээлдээ “Хэл аялгуу” хэмээх нэр томъёог хэрэглэсэн. Тэрээр “Монгол хэл хэмээгч нь ерөнхий, хийсвэр, бүхэл шинжтэй бөгөөд энэхүү хэл нь тусгай, бодитой, хэсэг зүйл болох халх, ойрад, буриад, өвөрмонгол хэл аялгуунуудаас бүрджээ. Гэвч нэг талаас тусгай, бодитой, хэсэг зүйл болох нутгийн аялгуу, жишээлбэл, халх аялгуу нь дотроо төв халх, дорнод халх, өрнөд халх хэмээх аман аялгуунуудад хуваагдах учир эргээд ерөнхий, хийсвэр, бүхэл зүйл болно. Энэхүү ерөнхий, хийсвэр, бүхэл зүйл болох аман аялгуу нь мөн дотроо салбар аман аялгуунуудад, тухайлбал, төв халх нь говийн халх, өвөрхангайн халх; дорнод халх нь дарьгангын халх; өрнөд халх нь сартуул халх, элжгэн халх, хотгойд халх, дархад гэх мэтээр мөн л тусгай, бодитой, хэсэг зүйлүүдэд хуваагдана. Үүний нэгэн адил Өвөрмонгол, Буриад, Халимаг (ойрад) монголчуудын хэлэлцэх хэл аялгуу нь нэг талаас ерөнхий, хийсвэр, бүхэл шинж бүхий бие даасан хэлний шинжтэй, нөгөө талаас тусгай, бодитой,

хэсгийн шинж бүхий нутгийн аялгууны шинжтэй юм. Тодруулбал, орчин цагийн Өвөр монгол, Буриад монгол, Халимаг монголчууд нь түүхэн гарал, уламжлал, хэрэглэж ирсэн бичиг соёл, одоо харилцан нэвтрэлцэх чанар зэрэг талаас нь авч үзвэл үнэхээр нэгэн монгол хэлний нутгийн аялгуунууд боловч эдүгээ өөрийн газар нутаг, хил хязгаартай; улс төр, засаг захиргааны хувьд биеэ даасан хийгээд өөртөө засах эрхтэй; хоёр ба холимог хэлтний зарим шинжийг агуулсан агаад зөв бичих, дуудах, найруулах, үгийн сангийн хэм хэмжээ бүхий бие даасан утга зохиолын аман болон бичгийн хэл, түүний суурь буюу баримжаа аялгуутай; өөрийн телевиз, радио, сонин, сэтгүүлтэй зэрэг олон зүйлээс үзэхэд бие даасан хэлний шинжтэй болжээ. Ийнхүү Өвөр монгол, Буриад монгол, Халимаг монголчуудын хэлэлцдэг хэл нь нэг талаас нутгийн аялгуу, нөгөө талаас бие даасан хэлний шинжтэй хоёрдмол чанартай болсон байна” [Батзаяа, 2008, Х. 15-16] гээд дараах загварыг гаргажээ:



Бүдүүвч 12. Монгол хэл, аялгуунуудыг ангилах тухай эрдэмтэн Г. Батзаяагийн санал

Ийнхүү эдүгээгийн монгол хэлэнд төв монгол хэл, дагуур, дуншаан, бао-ань, монгор, монгол, шар ёгур гэсэн 7 төрөл хэл; буриад, халимаг /ойрад/, өвөр монгол гэсэн 3 хэл аялгуу, нийт 10 хэл болон хэл аялгуут хамруулж болох бөгөөд тэр бүр нь дотроо олон, цөөн нутгийн аялгуутай гэж үзэж байна” [Төмөртоогоо, 2008. Х. 30–31] хэмээн нутгийн аялгуунаас бие даасан хэл үүсэж буй үйл явцыг тайлбарласан.

Эрдэмтэн Ж. Цолоо 2011 онд хэвлүүлсэн “Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу” бүтээлдээ дээр тэмдэглэсэн Д.Төмөртоогоогийн ангиллыг өөрчлөлгүйгээр дэмжээд, “Алтайн өвөг хэлнээс салбарлан гарсан монгол хэлний аялгуунууд нь нэг талаас анхны уугуул шинжээ хадгалсаар байна. Нөгөө талаас, монгол эх нутгаасаа тасран монголчуудын хэл аялгуу нь харь хэлний нөлөөнд автагдан, тус тусдаа өвөрмөц байдлаар хөгжсөөр дээр дурдсан арван нэгэн өөр хэл үүссэн” хэмээсэн байна. Тэрээр цааш нь “Орчин цагийн монгол хэлтэн гэдэг нь Монгол

улсын дотор багтаж байгаа олон ястны аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуугаар ярилцдаг халх-монгол, ойрад-монгол, буриад-монгол, өвөрлөгч монгол нар болно” хэмээн, Орос улсын нутагт оршин суугаа халимагчуудын хэл, Хятад улсын нутаг дахь Шинжаан-Уйгурын ойрад хэл, Монгол улсын баруун аймгуудаар нутагладаг ойрад монголчуудын аялгуу хэмээн ялгасан байна [Цолоо, 2011. Х. 19].


Эрдэмтэн Ю. Мөнх-Амгалан, Кан Шин нар 2014 онд хэвлүүлсэн “Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал” хэмээх бүтээлдээ “Одоогийн байдлаар монгол төрөл хэлний бүлд 10 гаруй хэлийг оруулж байна” [Мөнх-Амгалан, Кан Шин, 2014. Х. 3] гээд, мөн ордосыг биеэ даасан хэл хэмээн үзэж, монгор хэлийг дотор нь нарийвчлан мангуар, монгуар, монгул гэсэн гурван хэл болгон ангилбал дээрх тоо нэмэгдэхийг тэмдэглэжээ. Үүнд:



Бүдүүвч 13. Монгол хэлнүүдийг ангилсан эрдэмтэн Ю.Мөнх-Амгалан, Кан Шин нарын ангилал

Академич Д. Төмөртоогоо 2017 онд туурвисан “Монгол хэлний түүхэн хэлшинжилэлийн судалгаа” хэмээх бүтээлдээ “Монгол хэлтэнүүд нь хэд хэдэн өөр улсад тархан суурьшсан учир тэдгээр хэл аялгууг ангилах асуудал зарим талаар маргаантай хэвээрээ байна. Жишээлэхэд, ОХУ, БНХАУ-д оршин суудаг монгол угсаатнууд тухайн улсын доторхи олон үндэстэнүүдийн нэг, тэдний хэл нь мөн биеэ даасан ‘хэл’ гэж ойлгогдоно. Гэтэл Монгол улсын талаас авч үзвэл ОХУ дахь халимаг, буриад, БНХАУ-д оршин суугаа ойрад, буриадууд нь Монгол улс дахь ойрад, буриадуудын нэг хэсэг, тэдний хэл аялгуу нь ойрад, буриад аялгууны хилийн чанад

дахь салбар аялгуу болно. Бүр хөндлөнгөөс авч үзвэл дээрхи гурван улсад тархан оршин суугаа буриад, ойрадуудын хэл нь бие биеэ нөхөж, бие биетэйгээ нийлээд нэгэн бүхэл бүтэн ‘буриад хэл’, ‘ойрад хэл’-ийг бүрдүүлж байгаа билээ. Ийм нөхцөлд тэдгээрийг ‘биеэ даасан хэл’ гэж үзэх үү, ‘нэг хэлний салбар аялгуу’ гэж үзэх үү гэдэг асуудал маргаантай байгаа билээ... Монгол хэл аялгуунуудын дотроос Төв Монгол, Өвөр монгол, Ойрад, Буриад хэл нь бусад хэлний нөлөөнд автаагүй, монгол хэлнийхээ дотоод зүй тогтолын дагуу хөгжиж ирсэн зонхилох шинжтэй хэлнүүд юм” гээд, дараах байдлаар 10 хэл болгон ангилсан байна [Төмөртоогоо, 2017. Х. 149–174]:



Бүдүүвч 14. Монгол хэлнүүдийг ангилсан академич Д.Төмөртоогоогийн ангилал (2017)

Монгол хэлний нутгийн аялгуу судлалын бас нэгэн томоохон төлөөлөгч болох эрдэмтэн Г. Гантогтох 2018 онд хэвлүүлсэн “Монгол хэл аялгуу, үсэг бичгийн судлал” хэмээх эрдэм шинжилгээний өгүүллийн чуулгандаа “Монгол хэлний зүй тогтол, хэл сэтгэхүйн нэгдэл, нийтлэг нэгэн зэл тасраагүй тул олон монгол хэл аялгуу хэлний дотоод журам, хууль зүй тогтол, зүй зохисоороо нэгдмэл нэгэн цул монгол хэл хэмээн үзвээс зохилтой. Монгол хэл хэмээх ойлголт өнөөдөр хэд хэдэн янз байгаа нь тэдгээрийн байршил, газар нутгийн онцлог, засаг захиргааны хуваарь, улс орны харьяалал, угийн угсаа, омог отгийн нэрээр нэрлэж, олон хэмээн ангилахдаа тогтсон нэгэн шийдвэрт хүрч чадахгүй байна. Чингэвэл монгол хэлний дотоод зүй жам хийгээд нийтлэг журмыг дагаж, монголын олон аялгуунуудыг нийтлэг нэгэн зүй тогтолтой, хэл соёл заншлын нэгдмэл зэлтэй, хэл сэтгэхүйн хийгээд хэлний бүтэц, бүрэлдэхүүнийг агуулсан хийсвэр нэг л монгол хэл хэмээсэн ойлголт гэж томъёолж байна” [Гантогтох, 2018. Х. 130] хэмээн өөрийн байр сууриа илэрхийлсэн байдаг.

2020 онд эрдэмтэн Г. Батзаяа “Монгол хэл, аялгуунуудын нэр, үйлийн нөхцөлийн харьцуулсан судалгаа” хэмээх шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан ганц сэдэвт бүтээлийнхээ удиртгалд дээрх эрдэмтдийн ангиллыг шүүрдэж, эцэст нь өөрийн ангиллыг дэвшүүлжээ.

Ийнхүү монгол хэл аялгууны ангиллын талаарх, тухай тухайн үеийн судалгааны түвшин, цар хүрээтэй холбоотой, эрдэмтдийн харилцан адилгүй санал нь судалгааны түвшин нэмэгдэж, хүрээ тэлэх тутамд улам бүр төгөлдөржиж, монгол туургатны хэл яриаг бүрэн дүүрэн багтаах алхмуудыг хийсээр өнөөгийн түвшинд хүрсэн байна. Эл явцыг академич Л. Болд “Өнгөрсөн зууны үеэс эхлэн монголч эрдэмтэд монгол хэлний нутгийн аялгууг ангилан хуваахдаа нэг бол угсаатны зүйн үүднээс нь, эсвэл засаг захиргааны нэгжийн үүднээс асуудлыг авч үздэг байсан бөгөөд энэ нь нутгийн аялгууны тогтолцоог нээж харуулах шинжлэх ухааны үндэстэй шалгуур болж чадахгүй байлаа. Харин сүүлийн үед нутгийн аялгууг ангилахдаа хэлний хүчин зүйлийг гол болгохын

хамт монгол хэлний нутгийн аялгуунуудыг нэгтгэж байгаа болон аман аялгуу, салбар аман аялгуунуудыг ялгаруулж байгаа өвөрмөц болоод түгээмэл зүйлийг голлон анхаарсан нэгдсэн судалгааг амжилттай хийв” [Болд, 2012. Х. 48–56] хэмээн дүгнэсэн байдаг.

Хоёр. Хэл, аялгууны талаар хэрхэн авч үзэх тухай

Монгол хэл, аялгууны ангиллын энэхүү асуудал нь хэл шинжлэлийн болон хэл шинжлэлийн бус (угсаа гарвал, түүхэн замнал, түүний тухай олон улсын улс төрийн үзэл баримтлал, тухайн хэл аялгууг аль талаас нь, ямар харьцаанд авч үзэх гэх мэт) олон хүчин зүйлтэй холбоотой өргөн хүрээ хамаа бүхий асуудал юм. Түүнээс гадна аливаа хэл, ялангуяа амьд аман яриа тасралтгүй хөгжин хувьсаж байдаг учраас ойр зэргэлдээх бусад хэл, аялгуунаас нөлөө авах, ижилсэх, ялгарах, явцуурах, өргөжин хөгжих, хүн ам нь тухайн аялгуугаа хэрэглэхээ болих, мартах, сэргээх зэрэг хувиралт өөрчлөлт үргэлжилсээр байдаг. Иймээс хэл, аялгуу, түүний доторх аман болон салбар аман аялгууг ангилан хуваах явдал бол нэг удаа, нэг хүн хийгээд орхих ажил биш, тодорхой хугацааны хугацааны давтамжтай, байнга хөгжүүлж, шинэчилж байх хэрэгтэй ажил юм.

Академич Ш. Лувсанвандан 1959 онд нийтлүүлсэн “Монгол хэл аялгууны учир” өгүүлэлдээ “Аль нэгэн ястан, үндэстний төвлөрсөн улс төр задравч хэрэв улс төр, соёл, эдийн засгийн талаар байнгын холбоотой байвал тэдний хэл аялгуу заавал задарч, тус тусдаа биеэ даасан төрөл хэл болох албагүй юм. Монголын эзэнт гүрэн задарсны дараагаар Афганистаны моголууд, мөн Ганьсу мужийн монгорууд, төв монголчуудаасаа улс төр, соёл, эдийн засгийн талаар бүрмөсөн тасарсан боловч ар, өвөр монголчууд, мөн ойрад, буриад монголчууд бие биеэсээ ингэж бүх талаар тасарсангүй учраас тэдний хэл аялгуу ч мөн тус тусдаа биеэ даасан төрөл хэл болон хөгжсөнгүй, нэгэн монгол хэлний салбар аялгуу, аман аялгуу хэвээр үлджээ... Түүнчлэн Хөхнуур, Эзнээ гол, Алшаагийн монголчуудын үг хэл нь гарлаараа ойрад аялгуу боловч одоо төв аялгуу руу хэлбийж, завсрын

аман аялгуу болжээ. Мөн барга буриад нь халх-буриадын завсрын аман аялгуу юм” [Лувсанвандан, 2002. Х. 44–45] гэсэн зарчмын үүднээс дээр дурдсан ангиллаа дэвшүүлж байжээ. Гэхдээ тэр үеийн байдлаас одоо үеийн байдал өөр болсон нь ойлгомжтой юм.

Ялангуяа монгор, дагуур, дуншаан, бао-ань, зүүн ёгур, жич могол хэлнүүд төв монгол хэлнээсээ нэгэнт алслан холдож, өдгөө биеэ даасан хэл болон хөгжсөнийг эрдэмтэн судлаачид үндсэндээ хүлээн зөвшөөрч иржээ. Харин ойрад, буриад, мөн өвөр монголчуудын хэлэлцэж буй хэл яриа нь хэл үү, аялгуу юу гэдэг талаарх харилцан адилгүй саналын гол оногдохуун болж байна.

1996 онд Лондонд, 1998 онд Москвад хэвлэгдсэн “Атлас языков мира” (Дэлхийн хэлнүүдийн атлас)-д “Основным языком монгольской группы является язык на котором говорят в Монгольском народном республике и во Внутренней Монголии, автономном районе Китая.” /Үндсэн буюу төв монгол хэлээр Бүгд Найрамдах Монгол Улс, Өвөр Монголын монголчууд ба Хятад улсын доторх Монголын автономит мужийн монголчууд хэлэлцдэг/ [АЯМ, 1998. С. 47–48] хэмээсэн байдаг.

Түүнчлэн 2004 онд Өвөр Монголын Улаанхад хотноо хэвлэгдсэн “Монгол судлалын нэвтэрхий толь (Үг хэл үсэг бичиг)”-ийн “Монгол хэл аялгууны тархацын байдал” зурагт ар, өвөр монголын хэлийг нэгэн өнгөөр, харин дагуур, ду Сэцэнбаатар ншаан, могол, монгор, зүүн ёгур, бао-ань болоод халимаг, буриад хэлнүүдийг нэгэн ижил өнгөөр тэмдэглээд, монгол төрөл хэл (Mongolic languages) хэмээн нэрлэж, монгол хэлийг дотор нь өвөр (өвөр монгол) аялгуу, халх аялгуу, ойрад аялгуу, буриад аялгуу хэмээн дөрвөн том нутгийн аялгуунд хувааж үзсэн байна.

Өвөр Монголын эрдэмтэн Сэцэнбаатар “Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэлийн удиртгал” хэмээх бүтээлийнхээ “Хэл хийгээд нутгийн аялгууны ялгаа” хэсэгт хэл үү, нутгийн аялгуу юу гэдгийг шийдэх тухай дараах хэд хэдэн үндэслэлийг тайлбарласан байна. Үүнд: Аливаа хэлний доторх нутгийн аялгуу бусад нутгийн аялгуунуудтайгаа зэрэгцэн оршдог бөгөөд ганц нутгийн аялгуутай хэл

гэж байдаггүй. Нэг хэлэн доторх нутгийн аялгуунуудын үгийн үндсэн сан хийгээд хэл зүйн зохион байгуулалт үндсэндээ адил байдаг. Гэхдээ дан ганц үгийн сан, хэл зүйн зөрөө их, багаар бас асуудлыг бүрэн тодорхойлж чадахгүй. Мөн хэл яриануудын хоорондох шилжилтийн чанартай зүйл байх эсэх, улс төрийн байгууламж харьяалал, бичиг үсэг ба бичгийн хэл, нэг үндэстэн мөн эсэх нь асуудлыг шийдэх чухал хүчин зүйлс мөн боловч бас л бүрэн шийдвэрлэж дийлэхгүй. Тиймээс эдгээр нөхцөлүүдийг дан дангаар нь бус нийтэд нь ерөнхийлөн харгалзсан суурин дээр, нэгд. хэл аялгууны тус биеийнх нь онцлогийг үндэслэж, хоёрт. тухайн хэл аялгуугаар яригчдын үзэл ухамсрыг үндэслэж байгаад хэл ба нутгийн аялгууны ялгааг тодорхойлж болох юм. Хэл аялгууны тус биеийнх нь онцлог гэдэгт: 1. Нэгдмэл нэг хэлний дотоод дахь хэл яриа болж байх, 2. Тогтсон нутаг дэвсгэрийн тархацтай, 3. Тухайн хэлнийхээ нийтлэг онцлогийг хадгалсан мөртөө зохих хэмжээний өвөрмөц онцлогтой, 4. Авиа зүй, хэл зүй, үгийн сан, утга зүйн системт чанартай хэмээх үндсэн онцлогуудыг үзэж, хамтын дотоод хөгжлийн жам хуульд захирагдах эсэхийг нь чухалчилна. Адил бус орон нутгийн хүмүүс өөрсдөө чухам юу гэж үзэх ухамсар нь хэл ба нутгийн аялгууны ялгааг тодлоход чухал үйлдэл үзүүлнэ [Sečenbayatur, 2005. X. 5-10].

Академич Д. Төмөртоогоо дээрх бүтээлдээ “Өөр өөр улсад оршин сууж байгаа нэг хэлний салбар аялгуутанууд тус тусдаа бичигийн хэлтэй байвал тэдгээрийг биеэ даасан хэл гэж үзнэ гэсэн зарчим олон улсын хэмжээнд үйлчилсээр байна. Тэрхүү зарчмыг баримталвал дээрхи гурван улсад харьяалагдаж байгаа ойрад, буриадууд өөр өөр бичигийн хэлтэй байгаа учир тус тусдаа биеэ даасан хэл болж таарна” [Төмөртоогоо, 2017. X. 149–174] гэсэн зарчмыг дэвшүүлсэн байна.

Дээрх бүхий л эрдэмтдийн ангиллыг шүүрдэн ажиглахад: могол, монгор, дагуур, дуншаан, бао-ань, шар ёгурчууд монголчуудаасаа газар нутгаар алслан холдож олон зуун жил амьдарсны дүнд тэдний хэл яриа нь өөрийн дотоод зүй тогтлоороо хөгжихийн зэрэгцээ зэргэлдээх хэлнүүдийн нөлөөнд үлэмжхэн орж, эдүгээ холимог шинж бүхий бие даасан

хэл болон хөгжсөнийг олонх эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн байна. Нэгэн нэгдмэл монгол хэл хэмээн үзэж ирсэн эрдэмтэд ч А.Д. Рудневийн ангилалд монгол хэлний өрнөд бүлэгт афганистаны могол хэмээн дурдагдсаныг эс тооцвол эдгээр хэлнүүдийг дурдсангүй. Маргаант асуудлын гол оногдохуун нь буриад, ойрад, өвөр монголчуудын хэлэлцэж буй хэл яриа юм. Үнэндээ өвөр монгол, буриад монгол, ойрад монголчуудын хэлэлцдэг хэл яриаг уг гарвал, түүхэн замнал зэрэг талаас нь харвал монгол хэлний нутгийн аялгуу; өнөөдөр хилийн чанадад өөр улс оронд амьдарч буй байдал, өөрийн гэсэн утга зохиолын суурь болон баримжаа аялгуутай, түүнийхээ зөв бичих, дуудах, найруулах хэм хэмжээтэй, өөрийн гэсэн хэвлэл мэдээллийн сүлжээтэй зэрэг байдлыг харвал бие даасан хэлний шинжтэй – ийм хоёрдмол чанартай болсон байна.

Гэвч цаашид монгол хэлний өргөн хүрээнд бүрэн цогц судалгаа хийхийн тулд монгол хэлний өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага, нутаг нутгийн монголчуудын аман ярианы бодит ялгааг харьцуулан судлахын учир эрхбиш ямар нэг ангилалд тулгуурлах зүй ёсны шаардлага бидэнд тулгарч байна.

Гурав. Орчин цагт буй монгол хэл, нутгийн аялгуу, аман аялгуу, салбар аман аялгууны байдал

Бид дээр дурдсан “Атлас языков мира” [АЯМ, 1998] болон “Монгол судлалын нэвтэрхий толь: Үг хэл үсэг бичиг” [МСНТ, 2004]-ийн “Монгол хэл аялгууны тархацын байдал” зураг, бусад эрдэмтдийн санал, мөн Буриад болон Халимаг улсын хүн амын өөрсдийн үзэл баримтлалыг харгалзан үзэж дараах байдлаар ангилан хувааж байна.

ОХУ дахь Буриад, Халимаг улс болон бусад мужид тархан суурьшсан хүн амын хэлэлцдэг нь орос хэлний нөлөөг үлэмж хүртэж, холимог хэлний шинжтэй бие даасан буриад болон ойрад (халимаг) хэл болжээ. Харин Монгол улс болон Өвөр Монголын өөртөө засах орон, жич Шинжаан уйгурын өөртөө засах орон, Хятад улсын зарим мужаар тархан суурьшсан буриад, ойрад угсааны хүн амын хэлэлцдэг нь мон-

гол хэлний аялгуу юм. Учир нь Монгол улсын баруун аймгуудаар нутагладаг ойрадууд болон зүүн хойд аймгуудаар нутагладаг буриадуудын тухайн аймаг, сумандаа ярилцдаг аман яриа нь ойрад болон буриадаараа байж, өөр өөрийн онцлогоо хадгалж байвч халх аялгуунд суурилсан монгол утга зохиолын хэлний зөв бичих, найруулах хэм хэмжээ бүхий бичгийн хэлэнд захирагдаж, аман хэл нь ч тодорхой хэмжээгээр уусан жигдэрч байна. Түүнчлэн, Өвөр Монголын өөртөө засах орон, Шинжаан уйгурын өөртөө засах орон болон Хятад улсын зарим мужуудаар тархан суурьшсан буриад, ойрад угсаатан ард түмэн худам монгол бичгийн хэлэнд захирагдаж, өвөр монголын баримжаа – цахар аялгуунд тодорхой хэмжээгээр уусан жигдэрч байна.

Харин өвөр монголчуудын хэл яриаг бид одоохондоо өвөр аялгуу хэмээн томъёолж буйн гол шалтгаан нь хүн амын өөрсдийн үзэл бодол, хамгийн гол нь баримжаа авиа – цахар аман аялгуу нь халх аялгуутай харьцангуй ойр дөт байдагт оршино. Гэвч хэлэлцэгч хүн амын тоог авч үзвэл цахар аман аялгуутан эдүгээ 460000 орчим бөгөөд энэ нь өвөр аялгуутны 10,78% бол хорчин аман аялгуутан 2080000 орчим бөгөөд дангаараа 48,77%-ийг эзэлж байна (Үлдсэн 40,45% нь ордос, алшаа, баарин, харчин аман аялгуутнууд)¹. Хорчин аман аялгуу нь үгийн сангаас гадна хэл зүй, авиа зүйн түвшинд хятад хэлний нөлөөг үлэмж хэмжээгээр хүртэж, өдөр тутмын аман яриаг нь Монгол улсын хүн ойлгоход улам бүр төвөгтэй болж байна. Чухам энэ байдлыг авч үзвэл тэдний хэл яриа Орос дахь буриад, ойрад хэлний нэгэн адил холимог хэлний шинж бүхий биеэ даасан хэл болон хөгжиж буйг тэмдэглэх хэрэгтэй.

¹ https://mn.wikipedia.org/wiki/Өвөр_Монголын_Өөртөө_Засах_Орон

Ийнхүү, өнөөдөр МОНГОЛ ХЭЛ хэмээх ойлголтод монгол, ойрад, буриад, дагуур, дуншаан, бао-ань, монгор, могол, шар ёгур гэсэн 9 төрөл хэл багтаж, тус бүр дотроо нутгийн болон аман аялгуунуудтай, тэдгээрийн дотор салбар аман аялгуунуудтай болж байна. Үүнд:

1. Монгол хэл

1.1. Халх нутгийн аялгуу

1.1.1. Төв халхын аман аялгуу

1.1.1.1. Төв халхын салбар аман аялгуу

1.1.1.2. Говийн халхын салбар аман аялгуу

1.1.1.3. Өвөрхангайн халхын салбар аман аялгуу

1.1.2. Өрнөд халхын аман аялгуу

1.1.2.1. Өрнөд халхын салбар аман аялгуу

1.1.2.2. Сартуулын салбар аман аялгуу

1.1.2.3. Элжигэн халхын салбар аман аялгуу

1.1.2.4. Халхажсан хотгойдын салбар аман аялгуу²

1.1.2.5. Халхажсан өөлдийн салбар аман аялгуу³

1.1.2.6. Халхажсан дархадын салбар аман аялгуу⁴

² Өрнөд халхад багтдаг хотгойдууд нь XVI зуунд халхчуудтай нийлсэн ойрадуудаас гаралтай бөгөөд халхчуудын дунд олон зуун жил суусан тул халх аялгуунд үндсэндээ ууссан боловч ойрад аялгууны зарим шинжийг хадгалж үлдсэн байна [Төмөртоого, 2017. Х. 152]. Зүүнгарын улсын хотгойдын ноён Хархул зургаан мянгаад хүнтэй ойрадаас тасран халхад суурьшсан байна [Очир, 2011. Х. 237].

³ Архангай аймгийн Өлзийт сумын өөлдүүд төв халхчуудын дунд 250 орчим жил аж төрөн суурьшиж байна. 1931 онд орон нутгийн засаг захиргааны байгууллыг өөрчлөхөд Цэцэрлэгмандал аймгийг Архангай аймаг хэмээн нэрлэж, хуучин өөлдийн өмнөд хошуу, Баянбайшир уулын хошуу, хожимдоо Батцэнгэл уулын хошуу гэж байснаас салган, одоогийн Өлзийт сумыг байгуулсан ажээ. Тэд хэлний хувьд халх аялгуунд бараг бүрэн ууссан боловч ойрад аялгууны зарим онцлог элемент бас ч арилаагүй байна [Санжаа, Туяа, 2011. Х. 267–278].

⁴ Дархадчууд нь XVII зууны сүүлчээр Өндөр гэгээн Занабазарын шавь болж, албан татвараас чөлөөлөгдөн, дархан эрхтэй болсон хүмүүс бөгөөд тэдний хэл ярианд ойрад, буриад хэлний шинжүүд бий [Төмөртоого 2017. Х. 152], Дархад аялгуу нь анхандаа ойрад байснаа сүүлийн үеэс ойрад, буриад, халх аялгуу холилдох болсон [Санжеев, 1931, Өнөрбаян нар, 2020. Х. 63–64] “Дархад аялгуу нь ойрад, баруун халхын завсрын салбар аман аялгуу мөн” [Санжаа, Туяа, 2011. Х. 195].

1.1.2.7. Халхажсан цаатан салбар аман аялгуу¹

1.1.3. Дорнод халхын аман аялгуу

1.1.3.1. Дорнод халхын салбар аман аялгуу

1.1.3.2. Дарьгангын салбар аман аялгуу²

¹ Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ суманд цаа буга маллан амьдардаг цаатан хүмүүсийн хэл яриа, тэдний угсаа гарлын тухай монгол хэлний нутгийн аялгуу судлалд ховор тэмдэглэгджээ. Тэд эдүгээ дархад болон халхчуудын дунд аж төрөн суудаг. Тэд Тувагаас гаралтай бөгөөд настангууд нь одоо ч тува хэлээр ярьдаг. Өвөр Монголын эрдэмтэн Ж.Сэндмаа эвенк, хамниган нарын талаарх судалгааны бүтээлдээ ийнхүү дурджээ: “Эвенкчүүд бол ангийн нүүдлээр явдаг, тогтмол орон сууцгүй анчин үндэстэн юм. Тэд гүн уул, балар ойгоор араатан амьтан агнаж, аж төрдөг байсан тул жилийн дөрвөн улиралд зохицуулан, ан гөрөөг мөрдөн дагаж нутаг шилждэг байв. Цаа буга бол хөвд иддэг амьтан тул хөвд ургамлын судсыг даган, уул хайрхан, ой хөвчөөр шинэ соргог хөвд эрэн идшилдэг юм. Цаа бугын эзэн бологч бугачин эвенкчүүд мөн хөвд ургамлын судсыг даган цаа бугынхаа хойноос даган нааш цааш нүүдэллэн явдаг байжээ. Тиймээс анчин, бугачин эвенкчүүд нь Байгал далайн зүүнтээх ойт уул, Гадаад Хянган даваа, Хармөрөн, Жинхирмөрөн, Ниуман голын сав газраар нүүдэллэн шилжиж, хаа хүрсэн газартаа үйсэн гэрээ барьж, ангийн мах, сүүгээр идээ умдаагаа болгосон чөлөөт амьдралыг хийж байв.” [Сэндмаа, 2011. Х. 25–26]. Алтай язгуурын хэлний нэг болох манж түнгүс төрлийн эвенк хэлтэн буюу эвенкчүүд нь МЭ 1-р зуунд өмнөд талаараа Хятан улстай хил залган оршиж байсан Дундад улсын зүүн хойд орны Шивэй хэмээх анчин ахуйтай нэгэн угсаатнаас гаралтай. Шивэйчүүдийн зарим нь дагуур, манж, монгол угсаатанд тус тус уусан нэгдэж, голдуу хос хэлтэн болсон бөгөөд харин бусдад уусалгүй эх хэлээ хадгалан үлдсэн нь орчоон ба эвенк үндэстнүүд болжээ. Орчоон буюу ортон хэмээх нь цаатан хэмээх үг юм. Академич Б. Ринчен “Ортон хамниган, оронзон, орчон гэх мэт хамниган яс омгийн монгол нэрэнд орсон ор гэдэг үг бас монгол хэлнээ ор гөрөөс, ор буга гэх мэт үгэнд байдаг нь хамниган гаралтай язгуур үг бөгөөд хүний гаршуулж, уналга ачилгандаа хэрэглэдэг нэгэн зүйлийн мал болгосон бугын нэр болно.” [Ринчен, 2012. Х. 10] хэмээн тэмдэглэсэн байна. Тувагийн 26 овгийн дотор ооржак гэдэг овог байдаг. Орчоон бол манж-түнгүс, тува нь түрэг язгуурын хэлтэн бөгөөд аль аль нь алтай язгуурын хэлтнүүд юм. Эдгээр нүүдэлчин аймгуудын тухай баримтыг холбон бодож үзвэл ямар нэг холбоо байна гэж санана.

² Дорнод халхад багтдаг дарьгангачууд нь XVII зууны сүүлчээр халхын зүүн өмнөд хэсэг, Өвөр Монголын зүүн хойд хошуунаас таслан авч, манжийн хааны сүргийг хариулах алба гүйцэтгэж байсан хүмүүс юм. [Төмөртоого, 2017. Х. 152]. Гэвч авиазүйн зарим ховор үзэгдлүүд одоо хүртэл хадгалагдан үлдсэн сонирхолтой баримтуудыг эл нэг сэдэвт бүтээлийн дараагийн хэсгүүдэд дурдах болно.

1.1.3.3. Халхажсан үзэмчин, харчины салбар аман аялгуу³

1.2. Өвөр нутгийн аялгуу

1.2.1. Цахар аман аялгуу

1.2.1.1. Цахар салбар аман аялгуу

1.2.1.2. Сөнид салбар аман аялгуу

1.2.1.3. Үзэмчин салбар аман аялгуу

1.2.1.4. Хэшигтэн салбар аман аялгуу

1.2.1.5. Урад салбар аман аялгуу

1.2.2. Ордос аман аялгуу

1.2.2.1. Өмнөд салбар аман аялгуу

1.2.2.2. Хойд салбар аман аялгуу

1.2.3. Алшаа эзнээ аман аялгуу

1.2.3.1. Алшаа салбар аман аялгуу

1.2.3.2. Эзнээ салбар аман аялгуу

1.2.4. Баарин аман аялгуу

1.2.4.1. Баарин салбар аман аялгуу

1.2.4.2. Ар хорчин салбар аман аялгуу

1.2.4.3. Онниуд салбар аман аялгуу

1.2.4.4. Найман салбар аман аялгуу

1.2.5. Хорчин аман аялгуу

1.2.5.1. Жалайд салбар аман аялгуу

1.2.5.2. Дөрвөд салбар аман аялгуу

1.2.5.3. Горлос салбар аман аялгуу

1.2.6. Харчин түмэд аман аялгуу

1.2.6.1. Харчин салбар аман аялгуу

1.2.6.2. Хүрээ салбар аман аялгуу

1.2.6.3. Монголжин салбар аман аялгуу

1.3. Ойрад нутгийн аялгуу

1.3.1. Монгол улс дахь умард ойрадын аман аялгуу

1.3.1.1. Дөрвөдийн салбар аман аялгуу

1.3.1.2. Баядын салбар аман аялгуу

³ Үзэмчингүүд нь XVI зууны үеэс зүүн Монголын харьяанд багтаж байсан цахарын дөрвөн отгийн нэг бөгөөд XVII зуунаас одоогийн Өвөр Монголын Шилийн голын чуулганы харьяанд багтах болж, 1945 онд Өвөр Монголын Зүүн үзэмчин хошуунаас Дархан ван Минжүүрдоржийг даган Монгол улсад шилжин ирж, Дорнод, Сүхбаатар аймгийн нутгаар тархан суурьшжээ. Ийнхүү үзэмчингүүд нь угтаа өвөр аялгууны нэгэн салбар боловч олон жил халхчуудын дунд цөөхүүл оршин сууж, эдүгээ халх аялгуунд бараг бүрэн ууссан гэхэд болно. [Төмөртоого, 2017. Х. 153]. Манжийн эзэн хааны өртөөний албыг монгол газар гүйцэтгэж байсан харчид говиор нутаглана. Анх Энх-Амгалан хааны 58 /1715/ онд манж хааны зарлигаар монгол нутагт иржээ. [Цолоо, 2011. Х. 60].

1.3.1.3. Дөрвөдөжсөн хотон салбар аман аялгуу¹

1.3.1.4. Мянгадын салбар аман аялгуу²

1.3.2. Монгол улс дахь өмнөд ойрадын аман аялгуу

1.3.2.1. Захчины салбар аман аялгуу

1.3.2.2. Алтайн урианхайн салбар аман аялгуу³

1.3.2.3. Ариг урианхайн салбар аман аялгуу

1.3.2.4. Торгуудын салбар аман аялгуу

1.3.2.5. Өөлдийн салбар аман аялгуу

¹ Хотончуудын тухай эрдэмтэн Ю.Цэндээ “Тэд ойрад биш, түрэг, уйгар гаралтай хүмүүс юм. Ойрадын Галдан бошгот хаан 1670-аад онд Дундад Азийн уйгар, хотон нарыг байлдан эрхшээлдээ оруулж, цэрэгт дайчлах ба тариа тариулдаг байжээ... үг яриа нь бие даасан аялгуу биш бөгөөд эдүгээ монголын дөрвөд, баяд нарын дунд олон жил хольцолдон суусан тул уугуул ярианы хэлээ гэж, ойрад аялгуугаар, тэр дундаа дөрвөд аман аялгуугаар ярилцах болсон байна” хэмээн тэмдэглэжээ. [Өнөрбаян нар, 2020. Х. 63–64] Тэд Увс аймгийн Тариалан сумын нутагт 900 гаруй өрх 4500 орчим хүн ам аж төрөн суудаг. [Бадамхатан, 1995. Х. 5]. Мөн 1778 оны үед хотон нар Эжил голоос Улангомд ирж суурьшсан байна. [Цолоо, 2011. Х. 179].

² “XV-XVII зууны үеэс мянгадууд Хэм гол, Тагнын нуруу, Хөвсгөл нуурын баруун биеэр нутаглаж байсан бөгөөд Ойрад болон Шолой увшийн Алтан улсын захиргаанд, бас хотгойдуудтай хамт Манжийн захиргаанд ч орж явжээ. 1766 онд Улиастайн манж амбаны даалгавраар мянгадуудыг Алтай тийш нүүлгэн суурьшуулжээ. Мянгадууд одоо Ховд аймгийн Мянгад суманд бөөнөөр, Увс аймгийн Өлгий, Өмнөговь сумын дөрвөдүүдийн дунд цөөн тоогоор сууж байна. Алтайн урианхайчуудын дотор элкин байдалтай байна.” [Цолоо, 2011. Х. 63].

³ “XII зууны үеэс ойн анчин аймаг гэгдэх урианхайчууд Хөвсгөлийн ой тайгаас баруун зүг нүүдэллэн Алтайд очиж суурьшжээ. Одоо Шинжаан-Уйгурын өөртөө засах орны Алтай аймагт урианхайчууд сууна. Монгол улсын Баян-Өлгий аймгийн төв, Булган, Алтай, Алтанцөгц, Буянт, Сагсай зэрэг сум, Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан суманд урианхайчууд бөөнөөр сууна. Эдгээр урианхайчуудыг алтайн урианхай хэмээнэ. Хөвсгөл аймгийн Чандамань-Өндөр сумын Аригийн голоор ариг урианхайчууд нутаглана. Хэнтий аймгийн Бурхан халдун орчимд их хааны хоригийг сахиж үлдсэн урианхайчуудын хойчис байна. Говь-Алтай аймагт урианхан, хар урианхас овог байдалтай сууж байна. Дээрх урианхайчууд гарал нэгтэй монгол урианхайчууд юм” [Цолоо, 2011. Х. 62]. Харин язгуурын монгол эдгээр урианхайчуудаас өөрсдийгөө ялган, уйгар-урианхай хэмээн нэрлэж, түрэг хэлийг эх хэлээ хэмээн үздэг, түрэг, монгол хоёр хэлтэн хүмүүс Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр, Ханх суманд амьдардаг. Тоогоор цөөхөн тэдний өвөг дээдэс Хан Хөхий уулын орчмоор нутаглаж байгаад нүүдэллэж иржээ. [Болд, 2012. Х. 125].

1.3.3. Хятад улс дахь ойрадын аман аялгуу⁴

1.3.3.1. Торгуудын салбар аман аялгуу

1.3.3.2. Дөрвөдийн салбар аман аялгуу

1.3.3.3. Хошуудын салбар аман аялгуу

1.3.3.4. Захчины салбар аман аялгуу

1.3.3.5. Ойрадажсан урианхайн салбар аман аялгуу

1.3.3.6. Өөлдийн салбар аман аялгуу

1.3.3.7. Ойрадажсан Борталын цахар салбар аман аялгуу⁵

1.3.3.8. Хөхнуурын ойрадын салбар аман аялгуу⁶

1.4. Буриад нутгийн аялгуу

1.4.1. Монгол улс дахь Сэлэнгэ, Үүр голын буриад аман аялгуу

1.4.1.1. Цонгоолын салбар аман аялгуу

1.4.1.2. Түнхэн санагын салбар аман аялгуу

1.4.1.3. Ашбагадын салбар аман аялгуу

1.4.2. Монгол улс дахь Онон, Улз голын буриад аман аялгуу

1.4.2.1. Агын салбар аман аялгуу

1.4.2.2. Хорийн салбар аман аялгуу

1.4.2.3. Баргын салбар аман аялгуу

1.4.2.4. Буриадажсан хамниганы салбар аман аялгуу⁷

⁴ Ц. Өнөрбаян нар “Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу” бүтээлдээ Монгол, Хятад, Орос гурван улсын нутагт тархан суух ойрадуудыг нэгтгэн, “ойрад нутгийн аялгуу” хэмээн оруулаад, 12 ангилжээ [Өнөрбаян нар, 2020. Х. 6–64]. Үүнээс бид Хятад улсын нутагт суурьшин буй ойрадын аялгуудыг энд оруулав.

⁵ “Шинжааны Бортал жеугийн Рашаан сян ба Бортал хотод амьдарч буй 20000 орчим монголчууд бол Чин улсын үед баруун хязгаарыг сахихаар нүүдэллэж очсон цахарчууд эдүгээ ойрадуудтай олон зуун жил хамт нутагласнаар ойрадажсан нэгэн салбар аман аялгуу болжээ.” [Sečenbayatur, 2005. Х. 398].

⁶ 1686 онд 1000 илүү өрх хотгойд нар Хөхнуурт очиж, Манжид дагаар оржээ. [Очир, 2011. Х. 237].

⁷ Дээр дурдсан (цаатанчуудын тухай хэсэгт) эвенкчүүд нь түүхийн урт удаан хугацаа, амьдралын хэв маяг, улс гүрнүүдийн дайн дажин зэрэг шалтгаанаас болж нэг хэсэг нь Монгол улсад (хамниган буриад), нэг хэсэг нь Орос улсад (хамниган түнгүс болон якут), нэг хэсэг нь Хятад улсад (зарим нь дагуурчуудтай нийлсэн, зарим нь өвөр монголчуудтай нийлсэн хамниган түнгүс, зарим нь дан эвенк үндэстнээрээ) тархан суурьшжээ. Хамниган нь эвенкчүүдийн доторх нэг салбар угсаатан бөгөөд хамниган гэдэг нь монголчуудтай нийлсэн цагаас эхлэн нэрийдсэн нэр юм. “Хамниган эвенкчүүд мөн эртний үеийн аль нэгэн шатанд, эсвэл нэлээд урт түүхэн хугацаанаа монгол угсаатантай холилдон нийлж, хэдэн зуун жил өнгөргөжээ гэдгийг нь тэдний одоод тултал уламжлан ирсэн домог яриа,

1.4.3. Өвөр Монгол дахь буриад аман аялгуу

1.4.3.1. Шинэ баргын салбар аман аялгуу

1.4.3.2. Хуучин баргын салбар аман аялгуу

1.4.3.3. Буриадын салбар аман аялгуу

2. Ойрад (халимаг) хэл

2.1. Дөрвөдийн аман аялгуу

2.1.1. Дөрвөдийн салбар аман аялгуу

2.1.2. Их дөрвөдийн салбар аман аялгуу

2.2. Торгуудын аман аялгуу

2.2.1. Торгуудын салбар аман аялгуу

2.2.2. Волг-каспийн салбар аман аялгуу

3. Буриад хэл

3.1. Хори-ага нутгийн аялгуу

3.1.1. Хори салбар аман аялгуу

3.1.2. Ага салбар аман аялгуу

3.1.3. Мухаршэбэр салбар аман аялгуу

овог хал, хэл аялгуу, соёл заншил зэрэг нь гэрчилнэ.” [Сэндмаа, 2011. Х. 46] Тэд эхлээд Монгол, Орос хоёр улсад тархан суурьшиж байгаад, хожим Орос улсын Чита – Боорж нутгийн хамниганчууд болон шинэхээн буриадуудын нэг хэсэг нь Өвөр Монголын Хөлөнбуйр аймагт ирж, Хуучин барга, Шинэ барга, Буриад хошуу болон Эвенк үндэстний өөртөө засах хошуу байгуулан барга, буриадуудтай нэг нутагт амьдарснаас эдүгээ гурван улсад ийнхүү тархсан байна. Одоо тэдний дунд чивчин ~ шибшин, долоон хүү, зэрэг овог хал байхад Монгол улсын хамниганчуудын дотор сартуул, тугчин, бодонгууд, жалайр, цахар, урианхан хэмээх овог хал байдаг. “Хамниган” хэмээх үгийн утгын талаар “хам нэг зон” гэсэн буриад үг, “бөөгийн шашинтан” гэсэн түнгүс үг, эртний кабканас аймгийн нэрээс үүссэн үг гэх саналууд бий. Монголчуудтай нийлсэн хамниганчууд нь эртдээ ойн иргэдийн бүрэлдэхүүнд багтаж явсан бөгөөд XIX зууны үед Сэцэн хан аймагт, одоо Дорнод, Хэнтий аймгийн Биндэр, Дадал, болон Баян-Адарга, Дорнод аймгийн Цагаан-Овоо, Баян-Уул, Дашбалбар сумдад мөн Төв аймгийн Мөнгөнморьт суманд хэсэг бусгаар тархан суурьшиж байна. Хятад улсын нутагт өвөр монголчууд болон барга буриадуудтай холилдон аж төрж буй хамниган, эвенкчүүд нь их төлөв эвенк, монгол, хятад хэлтэй. Монгол улсад хэдэн зуун жил их төлөв буриадуудтай холилдон амьдарч буй хамниганчууд ч эх хэлээ тодорхой хэмжээгээр хадгалан, эвенк болон монгол хос хэлтэн болсон байна [Гэрэлмаа, 2015. Х. 42–50]. “Тэд XIII–XIV зуунаас монгол хэлээр ярих болсон бололтой учир тэдний одоогийн хэл аялгуу нь Нууц Товчооны хэл буюу дундад эртний монголчуудын хэлний онцлогийг хадгалсаар байгаа ажээ... тэд цэвэр буриад аялгуутан ч биш, халх аялгуутан ч биш, дундад эртний монгол хэлний үлдэгдэлтэй өвөрмөц монгол аялгуутан юм” [Нямбуу, 1992. Х. 190]. Тэдний монгол хэл нь дундад эртний монгол хэлний онцлогийг хадгалан үлдсэн бөгөөд халх, буриад аялгууны тусгал буй [Ринчен, 1969. Х. 17–19]. Харин бид Монгол улсын буриадуудтай холилдон суурьшиж, монгол-буриад аялгуутан болсны нь хувьд энэхүү бүтээлдээ буриадажсан хамниган хэмээн орууллаа.

3.2. Эхирид нутгийн аялгуу

3.2.1. Эхирид аман аялгуу

3.2.2. Качуг аман аялгуу

3.2.3. Баргажин аман аялгуу

3.2.4. Байкало-худар аман аялгуу

3.2.5. Ивалга аман аялгуу

3.3. Хонгоодор нутгийн аялгуу

3.3.1. Алайр-үнгын аман аялгуу

3.3.2. Түнхэн-аха-захаамин аман аялгуу

3.4. Цонгоол-сартуул нутгийн аялгуу

3.4.1. Цонгоол аман аялгуу

3.4.2. Сартуул аман аялгуу

3.5. Булагад нутгийн аялгуу

3.5.1. Боохон аман аялгуу

3.5.2. Доод үдийн аман аялгуу [Раднаев, 1991. С. 23].

4. Могол хэл**5. Монгор хэл**

5.1. Хүзү нутгийн аялгуу

5.2. Минхэ нутгийн аялгуу

6. Дуншаан хэл

6.1.1. Суонанба аман аялгуу

6.1.2. Ванжиажи аман аялгуу

6.1.3. Шижиажи аман аялгуу

7. Дагуур хэл

7.1. Чичигаарын дагуур нутгийн аялгуу

7.1.1. Бутха аман аялгуу

7.1.1.1. Ойгун салбар аман аялгуу

7.1.1.2. Нони салбар аман аялгуу

7.1.1.3. Нэмэр салбар аман аялгуу

7.1.1.4. Мэргэн салбар аман аялгуу

7.1.2. Чичигаар аман аялгуу

7.1.3. Морин даваагийн аман аялгуу

7.1.4. Мэргэн аман аялгуу

7.2. Хайлаарын дагуур нутгийн аялгуу

7.3. Шинжааны дагуур нутгийн аялгуу

7.4. Амурын дагуур нутгийн аялгуу

8. Шар ёгур хэл

8.1.1. Чинлүн аман аялгуу

8.1.2. Кэнле аман аялгуу

9. Бао-ань хэл

9.1. Жишишан нутгийн аялгуу

9.2. Тонрен нутгийн аялгуу

Канжа хэл¹**Дөрөв. Монгол хэл, аялгуугаар ярилцагч хүн амын тоо**

Хүн амын тоог сүүлийн үеийн тооллогын мэдээгээр нэгтгэж үзвэл:

Монгол хэлний төв халх аялгуутан Монгол улсын 2020 оны хүн амын дэлгэрэнгүй тооллогоор 2659985 байгаа бөгөөд энэ нь Монгол улсын хүн амын 83,8%-ийг эзэлж байна. Мөн дарьганга 36419, дархад 24549, цаатан 208, тува 2354, хотгойд 8583, үзэмчин 2308, харчин 154, сартуул 2023, элжигэн 1034 хүн тоологдсон байна.² Эдгээрийг нэмбэл **2737617 халх аялгуутан хүн байна**. Дээрх тооллогоор гадаадад оршин суугаа 122301 иргэн тоологдсон байна. Энэ тооны дотор ястны задаргаа байхгүй тул хэрэв халхчуудын тоон дээр нэмж үзвэл 2859918 болох юм.

Өвөр аялгуутан: цахар аман аялгуутан 460000 орчим, ордос аман аялгуутан 150000 орчим, алшаа эзнээ аман аялгуутан 44600 орчим, баарин аман аялгуутан 730000 орчим, хорчин аман аялгуутан 2080000 орчим, харчин түмэд аман аялгуутан 800000 орчим байна [Sečenbayatur, 2005. X. 206]. Эдгээрийг нэмбэл **4264600 орчим өвөр аялгуутан хүн байна**.

Ойрад аялгуутан Монгол улсын хүн амын 2020 оны тооллогоор: дөрвөд 83719, баяд 63775, захчин 37407, урианхай 29021, өөлд 14666, торгууд 15596, хотон 12057, мянгад 8125, хошууд 382 хүн тоологдсон³ бөгөөд нэмбэл 264748 бай-

на. “Дундад улсын ойрад аялгууны орон дахь монгол үндэстэн сүүлийн үеийн бүртгэлээр нийт 270000 гаруй байх бөгөөд үүнд: Шинжаанд 160000 гаруй, Хөхнуур мужид 100000 гаруй, Гансу мужид 15000 орчим (үүнд ойрад аялгуутан 5000 орчим) хүн буй. Хөхнуур мужийн Хуаннаны Төвөд үндэстний өөртөө засах жегүйн Лхенаны монгол үндэстний өөртөө засах шяны 20000 гаруй хошууд монголчуудын дийлэнх нь төвөд хэлтэн болсныг гаргавал бусад газрынх нь мөн ойрад аялгуугаараа ярилцдаг” [Sečenbayatur, 2005. X. 398]. Монгол улс болон Хятад улс дахь ойрад аялгуутны тоог нэмбэл **534748 ойрад аялгуутан хүн байна**.

Буриад аялгуутан Монгол улсын хүн амын 2020 оны тооллогоор: буриад 43661, барга 2832, хамниган 384 тоологдсон бөгөөд⁴ нэмбэл 46877 байна. “2000 оны бүртгэлээр барга буриад аялгуутан Дундад улсад 110000 гаруй байна” [Sečenbayatur, 2005. X. 434]. Эдгээрийг нэмбэл **156877 буриад аялгуутан хүн байна**.

Ойрад хэлтэн: Орос улс дахь ойрадууд Халимагийн автономит улс болон Астрахань, Ростов, Волгоград муж, Ставрополь хязгаарт, мөн Киргизийн Иссык-Куль нуур, мөн Москва хотод оршин сууж байна. “Орост 2010 онд 80546 хүн халимаг хэлтэй болохоо мэдүүлсэн нь 183372 халимагийн 43.9%-тай тэнцэнэ.”⁵ Үүнээс гадна Уулын Алтай улсын урианхайчууд 80000 орчим, Тува улсын ойрадууд 206000 орчим байна. Гэвч Уулын Алтай улс эдүгээ хэлний хувьд түрэг, кипчак, орос хэлтэй холилдсон бөгөөд үгийн сангийн 40 орчим хувь нь монгол үг байдаг гэсэн судалгаа бий.⁶ Мөн Тува улс 309000 хүн амтайгаас гуравны хоёр нь тожин, соёд, монгол, буриад, урианхай, тагна тува зэрэг монгол овогтнууд, бусад нь орос, хакасс, киргиз, уйгар зэрэг бусад үндэстэн ястангууд юм [Нямаа, Батцэцэг, 1995. X. 110]. Гэвч одоо Тувагийн хүн ам албан ёсоор тува хэлээр ярилцдаг. Иймээс бид ойрад хэлтэн хүн амын тоонд зөвхөн Халимагийн автономит улс болон Оросын зарим мужаар суурьшсан ойрад (хали-

¹ “Хөхнуур мужийн Хуаннаны төвөд үндэстний өөртөө засах жегүй Жижа шяны Кан-ян балгасанд нутгийн хэлээр ярилцдаг нэг бүлэг хотончууд байдаг. Тэдний хэл яриаг өнгөрсөнд бао-ань хэлний нэг нутгийн аялгуу гэж үзэцгээдэг байсан. Сүүлийн жилүүдэд эдгээр хотончуудын хэл яриаг монгол төрлийн бие даасан бас нэг хэл – канжа хэл гэж үзэх болж байна. Дээр зууны ерээд онд хийсэн байцаалтаар канжягийн хотончууд нийт 2000 гаруй байх бөгөөд 480 гаруй хүн нь канжа хэлээ мэддэг байсан гэнэ. Гэтэл Тайваний эрдэмтэн Шиюу Су Еин-ийн сүүлийн үед хийсэн байцаалтаар одоо канжа хэлээр ярилцдаг хүн 180 орчимхон үлдээд буй. [Sečenbayatur, 2005. X. 91–92].

² mn.wikipedia.org/wiki/Бүгд_Найрамдах_Монгол_Улс

<http://registrationmongolia.com>

³ hun_am_toollogo.pdf&ln (Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн)

⁴ hun_am_toollogo.pdf&ln (Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн)

⁴ hun_am_toollogo.pdf&ln (Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн)

⁵ <https://mn.wikipedia.org/wiki/Халимаг>

⁶ Өвөр Монголын “Одон” телевиз, “Тэр холын Уулан Алтай”, 2019-01-06.


маг) хэлтэн хүн амын тоог авч **ойрад хэлтэн 80546 хүн байна** хэмээн тооцож байна.

Буриад хэлтэн: Орос улсад Буриадын автономит улс болон Чита муж, Эрхүү мужид төвлөрөн суусан. “Оросод **буриад хэлтэн 461389 хүн байна.**”¹

Могол хэлтэн² болон канжя хэлтэн тодорхойгүй, дагуур хэлтэн 132000 орчим хүн [Sečenbayatur, 2005. X. 86–87], монгол хэлтэн

290000 орчим хүн [Sečenbayatur, 2005. X. 87–99], бао-ань хэлтэн 15000 орчим хүн [Sečenbayatur, 2005. X. 88–89], дуншаан хэлтэн 621500 орчим хүн [Sečenbayatur, 2005. X. 89–90], зүүн ёгур хэлтэн 7000 орчим хүн байна [Sečenbayatur, 2005. X. 90–91].

Энэ бүхнийг нэмж үзвэл **нийт монгол ба монгол төрөл хэлтэн 9423578 буюу есөн сая таван зуун мянга орчим хүн байна** гэсэн багцаалсан тоо гарах юм. Тоог графикаар үзүүлбэл:



Бүдүүвч 15. Нийт монгол ба монгол төрөл хэлтэн хүн амын тоо

Дүгнэлт

Цаашид монгол хэлний өргөн хүрээнд бүрэн цогц судалгаа хийхийн тулд монгол хэлний өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага, нутаг нутгийн монголчуудын аман ярианы бодит ялгааг харьцуулан судлахын үүднээс бид өнөөгийн монгол хэл, нутгийн аялгуу, түүний доторх аман ба салбар аман аялгууг ийнхүү ангилан хувааж байна. Өнөө үед “Монгол хэл” хэмээх нэрийн дор 9 хэл, 19 нутгийн аялгуу, 37

аман аялгуу, 70 орчим салбар аман аялгуу байна. Эдгээр хэл, аялгуугаар ярилцдаг арван сая шахам хүн байна. Энэхүү ангилал, тогтолцоо, тоо баримт нь цаашид монгол хэлний арвин баялаг байдал, гарал, хувирал хөгжил, хэлний нэгжүүдийн хөгжлийн зүй тогтол зэрэг олон зүйлийн судалгаанд, мөн эдгээр хэл, аялгуу бүрийг хадгалан хамгаалж, ярилцагч хүн амын тоог цөөрүүлэхгүй байх бодлогыг тодорхойлох зэрэг асуудалд нэмэр, тулгуур болох юм.

РЕЗЮМЕ

Проблема классификации диалектов монгольского языка до сих пор не разрешена. Но вместе с тем необходимость классификации диалектов, говоров современного монгольского языка реально существует. Для того, чтобы проводить широкомасштабные комплексные исследования языка монгольских народов, сначала нужно определить нынешнее состояние и тенденции дальнейшего развития монгольского языка, а также провести сравнительное изучение состояния и развития отличительных черт диалектов, говоров на различных территориальных локациях Монголии. Судя по классификации исследователей, в на-

стоящее время к монгольскому языку относят 9 языков, 19 диалектов, 37 говоров и примерно 70 подговоров. Считается, что около 10-ти миллионов людей являются носителями монгольского языка и его различных диалектов. Эта классификация, является основным ориентиром для изучения многих аспектов, таких как происхождение, эволюция, богатство и закономерности развития языковых единиц монгольского языка. Следовательно, мы надеемся, что наши исследования окажут существенное влияние на политику сохранения разнообразия диалектов и говоров монгольского языка, не допущения снижения населения, говорящего на этих диалектах и говорах.

НОМ ЗҮЙ

АЯМ, 1998: Атлас языков мира / Пред. Дж. Эйтчисон, Пер. Т. Парфенова, М., 1998.

Atlas yasykov mira / Pred.. Dzh. Eichison. Per. T. Parfeonova [Atlas of the Languages of the World]. Moskva, 1998.

Бадамхатан, 1995: С. Бадамхатан, Увсын хотон ястан, Уб., 1995.

S. Badamkhatan Uvsyn khoton yaztan [The peoples of Hoton Uvs] Ulaanbaatar, 1995.

Батзаяа, 2008: Г. Батзаяа, Монгол хэлний нутгийн аялгуунуудын авианы харьцуулал Уб., 2008.

G. Batzaya Mongol khelnii nutgiyn ayalgуunuudyn aviany khar'tsuulal [Phonological comparison of local dialects of the Mongolian language]. Ulaanbaatar, 1995.

Болд, 2012: Л. Болд, Нутгийн аялгуу судлал // Монгол хэл шинжлэлийн түүхийн асуудал. Улаанбаатар, 2012. х.48–57.

L. Bold Nutgiin ayalguu sudlal // Mongol khel shijleliin tuukhiin asuudal [Study of Dialects // Problems of Mongolian Linguistic history]. Ulaanbaatar, 2012. Pp.48–57.

Владимирцов, 1929: Б. Я. Владимирцов Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Ленинград. 1929.

B. Y. Vladimirtsov Sravnitel'naya Grammatika Mongolskovo Pismennovo yasyka i Khalkhaskovo narechiya [Comparative Grammar of Mongolian written Language and Khalkh dialect]. Leningrad, 1929.

Гантогтох, 2018: Г. Гантогтох Монгол хэл аялгуу, үсэг бичгийн судлал. Улаанбаатар., 2018.

G. Gantogtokh Mongol khel ayalguu, useg bichgiin sudlal [Study of Mongolian Languages, Dialects and Alphabets]. Ulaanbaatar, 2018.

Гэрэлмаа, 2015: Го. Гэрэлмаа Олон улсын Улаанбаатарын их сургуулийн хээрийн шинжилгээний анги Хэнтий аймгийн нутгаар / Тайлан сэтгүүлийн аян замын тэмдэглэл. Уб., 2015.

Go. Gerelmaa Olon ulsyn Ulaanbaatarын их surguuliin keeriin shinzhilgeemii анги Khentii aymgiin nutgaar [Department of Field Research of the Khentei Aimag of the International Ulaanbaatar University / Journey Notes in the Report Journal]. Ulaanbaatar, 2015.

Лувсанвандан, 2002: Ш.Лувсанвандан Монгол хэл аялгууны учир // Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудлууд. Улаанбаатар. 2002. Х. 36–55.

Sh. Luvsanvandan Mongol khel ayalguuny учир. 1959 // Mongol khelnii aviazuin onol praktikiin asuudluud [Reason of Mongolian Language and Dialects. 1959 // Problems of Theory and Practice of Mongolian Phonetics]. Ulaanbaatar, 2002. Pp. 36–55.

Мөнх-Амгалан, Кан Шин, 2014:Ю. Мөнх-Амгалан, Кан Шин Орчин цагийн монгол хэлний бүтэвэр судлал. Улаанбаатар. 2014.

Yu. Munkh-Amgalan, Kan Shin Orchin tsagiin mongol khelnii buteever sudlal [Study of Modern Mongolian Morphology]. Ulaanbaatar, 2014.

Мөөмөө нар, 1984: С. Мөөмөө, Ю. Мөнх-Амгалан Орчин үеийн монгол хэл аялгуу. Улаанбаатар, 1984.

S. Muiitui, Yu. Munkh-Amgalan Orchin uyiin mongol khel ayalguu [Modern Mongolian Languages and Dialects]. Ulaanbaatar, 1984.

МСНТ, 2004: Монгол судлалын нэвтэрхий толь (Үг хэл, үсэг бичиг). Улаанхад, 2004.

Mongol sudlalyn neverterkhii toli (Üg kel, üseg bichig). [Encyclopedia of Mongolian Studies]. Ulaankhad, 2004.

Нямаа, Батцэцэг, 1995: А. Нямаа, Ч. Батцэцэг Орос дахь монгол угсаатны улсууд. Улаанбаатар, 1995.

A. Nyamaa. Ch. Battsetseg Oros daki mongol ugsaatny ulsuud [Mongolian Ethnic States in Russia]. Ulaanbaatar, 1995.

Нямбуу, 1992: Х. Нямбуу Монгол угсаатны зүй. Улаанбаатар, 1992.

Kh. Nyambuui Mongol ugsaatny zui [Mongolian Ethnography]. Ulaanbaatar, 1992.

Очир, 2011: А.Очир Монголын түүхэн судалгаа III. Улаанбаатар, 2011.

A. Ochir Mongolyn tuukhiin sudalgaa [Study of Mongolian History]. Ulaanbaatar, 2011.

Өнөрбаян нар, 2020: Ц. Өнөрбаян, Ю. Цэндээ, Л. Цэрэнчимэд, Г. Батзаяа Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. Уб., 2020.

Ts. Unurbayan, Yu. Tsendee, L. Tserenchimed, G. Batzaya Orchin tsagiin mongol khelnii nutgiin ayalguu [Dialects of the Modern Mongolian Language]. Ulaanbaatar, 2020.

Рамстедт, 1908: Г. И. Рамстедт Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, СПб., 1908 //Хэл зохиол. 4-р Боть. I-IV. Уб, 1967.

G. I. Ramstedt Sravnitel'naya Fonetika Mongolskovo pismennovo yasyka i khalkhasko-urginskovo govora [Comparative Phonetic of Mongolian written Language and Khalkh-Urguu subdialect. 1908 // Language and Literature. T. IV. Fasc I-IV]. Ulaanbaatar, 1967.

Раднаев, 1991: Э. Р. Раднаев Буряад хэлэнэй диалектологи. Улан-Удэ. 1991.

E. R. Radnayevev Buryad khelnei dialektologi [Dialectology of Buryat Language]. Ulan-Ude, 1991.

Ринчен, 1969: Б. Ринчен Монгол ард улсын хамниган аялгуу. Улаанбаатар, 1969.

B. Rinchin Mongol ulsyn khamnigan ayalguu [Khamnigan dialect of Mongolian]. Ulaanbaatar, 1969.

Руднев, 1908: А. Д. Руднев Опыт классификация монголов по наречьям. М., 1908.

A. D. Rudnev Opyt Klassifikatsiya mongolov po narechyam [Classification of Mongolian Dialects]. Moskva, 1908.

Санжаа, Туяа, 2011: Ж. Санжаа, Д. Туяа Дархад аман аялгууны урт эгшиг авиалбар // Монгол хэлний авиа – авиалбар – их авиалбар. Улаанбаатар, 2011. Х.190–196.

J. Sanjaa, D. Tuuya Darkhad aman ayalguunii urt egshig [Long vowels of Darkhat subdialect // Sound-Phoneme-Giperphoneme of Mongolian Language]. Ulaanbaatar, 2011. P.190-196.

Санжеев, 1931: Г. Д. Санжеев Дархатский говор и фольклор, Ленинград. 1931.

G. D. Sanjyuev Darkhatskii govor I folklor [Darkhat Subdialect and Folklor]. Leningrad. 1931.

Санжеев, 1957: Г. Д. Санжеев Монгол хэл аялгууны учир /орч. Ш.Лувсанвандан. Улаанбаатар, 1957.

G. D. Sanjyuev Mongol khel ayalguunii uchir [Reason of Mongolian Language and Dialects /translated by Sh. Luvsanvandan]. Ulaanbaatar, 1957.

Төмөртоого, 1992: Д. Төмөртоого Монгол хэлний түүхэн хэлзүй. Улаанбаатар, 1992.

D. Tumurtogoo Mongol khelnii tuukhen khel zui [Historical Grammar of Mongolian Language]. Ulaanbaatar, 1992.

Төмөртоого, 2008: Д. Төмөртоого Монгол хэл шинжлэлийн онол, түүхийн асуудлууд. Улаанбаатар, 2008.

D. Tumurtogoo Mongol khel shinjileiin onol, tuukhiin asuudluud [Theoretical and Historical Problems of Mongolian Linguistic]. Ulaanbaatar, 2008.

Төмөртоого, 2017: Д. Төмөртоого Монгол хэлний түүхэн хэлшинжилэлийн судалгаа. Улаанбаатар, 2017.

D. Tumurtogoo Mongol khelnii tuukhen khel shinjileiin sudalgaa [Historical Linguistic Study of Mongolian Language]. Ulaanbaatar, 2017.

Цолоо, 2011: Ж. Цолоо Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. Уб., 2011.

J. Tsoloo Orchin tsagiin mongol khelnii nutgiin ayalguu [Dialects of Modern Mongolian Language]. Ulaanbaatar, 2011.

Čenggeltei, 2010: Čenggeltei Dundad uls daki mongol turul kel ba nutgiin ayalguuny yerunkhii baidal [The General State of the Mongolian Languages and Dialects in the China]. Khukh khot. 2010.

Doerfer, 1964: G. Doerfer *Classification und Verbreitung der mongolischen Sprachen*. Wiesbaden. 1964. [Classification and Dispersion of Mongolian Languages]. Wiesbaden, 1964.

Janhunen, 2003: J. Janhunen (ed.) *The Mongolic Languages* // *Pouledge Language Family Series*. London, New-York. 2003. P.178–181.

Sečenbayatur, 2005: *Sečenbayatur* Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэлийн удиртгал Хөх хот, 2005.

Sečenbayatur Mongol kelnii nutgiin ayalguuny шинжлэлийн удиртгал [Analytical materials of the Dialects of Mongolian Language]. Khukh khot, 2005.

THE HISTORY AND CURRENT SITUATION OF CLASSIFICATION OF THE MONGOLIAN LANGUAGES AND DIALECTS

Gerolt-Od BATZAYA

Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

The problem within classification of dialects of the Mongolian languages has not been resolved yet. However at the same time, the urge to classify dialects of the modern Mongolian languages really exists. In order to *conduct large-scale comprehensive studies of the language of the Mongolian-speaking peoples*, it is first necessary to determine the current state and trends in the further development of the Mongolian language, as well as to conduct a comparative study of the state and development of the distinctive features of dialects, in various territorial locations of Mongolia. Due to the classification of researchers, the Mongolian language currently includes 9 languages, 19 dialects, 37 subdialects and approximately 70 oral subdialects. It is believed that about 10 million people are native speakers of the Mongolian language and its various dialects. This classification is the main reference point for studying many aspects, such as the origin, evolution, richness and patterns of development of the language units of the Mongolian languages. Therefore, we hope that our research will have a significant impact on preserving the diversity of dialects of the Mongolian languages, to prevent the decline in the number of people speaking these dialects.

Key words: Mongolian languages, dialects, classification, history, current status: language, dialect, oral dialect, branch oral dialect, population

About the author: **Gerolt-Od BATZAYA**, Dr. Sci. (Philology), Associate Professor, Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (batzaya@mas.ac.mn).